



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны 06 дугаар сар)

ГАРЧИГ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ V САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН .3

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ	3
1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил	3
1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол.....	3
1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол.....	4
1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ	5
1.1.4. Ур чадвартай ажилчны (Е-7-4) виз руу шилжихийг дэмжих үйлчилгээ .	6
1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)	8
1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо	8
1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт	8
1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт.....	8
ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ	10
2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ.....	10
2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд	10
2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ	10
2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)	11
ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ	13
3.1. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ	13
3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ	14
3.2. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил	14

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ V САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны VI сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.06.01 - 2026.06.30)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **393** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилж, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал: 13,964,123 вон, нутаг буцах зардал: 1,540,010 вон, ажил олгогчоос олгох 13 дахь сарын цалин: 7,000,000 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс: 8,969,224 вон, эмнэлгийн үнэ төлбөргүй үйлчилгээ 830,000 вон зэрэг нийт **32,303,357** воныг Монгол Улсын **34** иргэнд (давхардсан тоогоор) олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

- Иргэн Б.Б (Е-9) нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, нутаг буцах зардал 511,000 воныг дансаар, 13 дахь сарын 2,902,284 воныг хилээр гарахад нь бэлнээр олгосон.
- Иргэн Ц.О (Е-9) нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын 2,242,999 воныг хилээр гарахад нь бэлнээр олгосон.
- Иргэн Б.Б (Е-9) нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, нутаг буцах зардал 524,000 воныг дансаар, 13 дахь сарын 6,686,640 воныг хилээр гарахад нь бэлнээр олгосон.

- Иргэн Ж.Э-гийн (Е-9) нутаг буцах замын зардал 500,000 вон болон Самсунг даатгалд байршсан 13 дахь сарын цалин 2,132,200 воныг нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Б.С-ийн (Е-9) олгогдоогүй цалин хөлсний тодорхойлолтыг авч Хөдөлмөр халамжийн газар болон Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газраас 4,286,000 воны цалин хөлсийг нэхэмжлэн хүсэлтийг гаргав.
- Иргэн У.С (Е-9), Э.Т (Е-9), Б.Т (Е-9) нарын Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал нэхэмжлэх хүсэлтийг хүлээн авч баримт бүрдүүлэн илгээсэн.
- Иргэн М.Б (Е-9) нь ажил олгогчоос хууль зөрчсөн заалт бүхий хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зурахыг шаардаж буй тухай өргөдөл ирүүлсний дагуу Хөдөлмөрийн хэлтэс (... 고용노동지청)-т гомдлыг гаргасан. Улмаар ажлаас гарах мэдэгдлийг хийлгэж, ажил хайх хугацаанд байрлах байргүй тул ... 이주노동자센터-д байрлуулахаар тохирон тухайн иргэнийг тус байранд хүргэж өгсөн.
- Иргэн Г.С-ийн (Е-9) ажлын орчин, нөхцөлтэй танилцах, ажил олгогчтой үүссэн асуудлыг шийдвэрлэхээр мужийн сумын нутаг дэвсгэрт байрлах фермд (нийт 580км) 2026.05.26-ны өдөр очиж ажилласан. Тухайн иргэн нь ажил эхэлсэн өдөр буюу 2025.12.18-ны өдрөөс хойш нэг ч удаа амраагүй, ажил олгогчийн дарамт их, доромжлох, гар далайх зэргээр айлган сүрдүүлж, сэтгэл санааны дарамт үзүүлснээс даралт ихсэх, нойр хулжих, ... болсон гэх шалтгаанаар 2026.05.26-ны өдөр тус төвд өргөдөл гаргаж ажлын байр солиход туслалцаа үзүүлэхийг хүссэн. Хүсэлтийг шийдвэрлэж ажлаас гарах мэдэгдлийг 2026.06.04-ний өдөр баталгаажуулсан.
- Иргэн Э.М-ийн (Е-9) ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээг сунгаагүй асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авч Цагаачлалын албаны хүний эрх, эрх ашгийг хамгаалах багт гомдлыг гаргасан.
- Иргэн Х.А-гийн (Е-9) ажлын байр солих өргөдлийн дагуу ажил олгогчтой холбогдож, харилцан зөвшилцсөнөөр ажлын байр солих мэдэгдэл хийлгэв.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

- Иргэн Б.Н-ийн (визгүй) үйлдвэрлэлийн осолд өртөж ажилгүй байсан үеийн цалин хөлсийг нэхэмжлэх гомдлыг 2026.06.05-ны өдөр хүлээн авч Каннам болон Чонан Хөдөлмөр халамжийн хэлтэст 7 удаагийн хүсэлтийг гарган 2,846,851 воныг олгуулсан.
- Иргэн Э.Г-гийн (визгүй) хууль бусаар ажилласан 13 дахь сарын цалин болох нийт 3,259,224 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Д.А-гийн (визгүй) үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн өргөдлийг Хөдөлмөрийн хэлтэст гаргаж, даатгалаас 7,000,000 вон олгуулсан ба зөрүү мөнгийг нэхэмжилсэн өргөдлийг Сөүлийн хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төвд хүргүүлсэн.
- Иргэн Г.С-ийн (G-1) interior компанид ажиллаад авч чадаагүй цалин 1,440,400 воныг нэхэмжлэн олгуулав. Мөн тухайн иргэний нураалт, хог хаягдлын 2 компанид ажилласан нийт 4,586,000 воныг барагдуулахаар ажиллаж байна.
- Иргэн А.З-гийн (визгүй) нутаг буцах зардал 529,010 воныг нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Ж.Б-гийн (визгүй) олгогдоогүй цалин 360,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.



- Иргэн Б.Ц-гийн (G-1) олгогдоогүй цалинг нэхэмжилж Хөдөлмөрийн хэлтэст (대구서부고용노동지청) өргөдөл гарган 3,950,000 воныг олгуулав.
- Иргэн Н.Б-гийн (визгүй) ажлаас гарсны дараах цалин нэхэмжилсэн хүсэлтийг 2026.06.05-нд хүлээн авч Хөдөлмөрийн хэлтэс (경기지방고용노동지청)-т гомдлыг гаргав.
- Иргэн Г.Г, Г.Б нарын олгогдоогүй цалин хөлсний өргөдлийг хүлээн авч Тэгү баруун бүсийн Хөдөлмөрийн хэлтэст гомдлыг гаргав.
- Иргэн Ц.О (визгүй), Б.Т (визгүй) нарын хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байхдаа төлсөн нутаг буцах зардлыг нэхэмжлэн холбогдох баримтыг бүрдүүлж Аж үйлдвэр хүний нөөцийн хэрэг эрхлэх газарт (서울남부지사) хүргүүлсэн.
- Иргэн Ж.Б (визгүй) барилга дээр ажил гүйцэтгээд авч чадаагүй нутаг буцсан 5,325,000 воны цалингийн өргөдлийн хүрээнд ажил олгогч болон хариуцсан менежертэй нь холбогдон нэхэмжилсэн.
- Иргэн Э.Т-гийн (визгүй) барилгын ажил гүйцэтгээд авч чадаагүй 3,233,000 воныг ажил олгогчоос нэхэмжилж, 7 дугаар сардаа багтаан 2 хувааж барагдуулахаар тохирсон.
- Иргэн Ч.О-гийн (визгүй) ажлаас гарсны дараах тэтгэмж 6,649,746 олгуулах хүсэлтийг хүлээн авч тооцооллыг хийн ажил олгогчтой тохиролцохоор ажиллаж байна.
- Иргэн Б.Х (визгүй), Б.Б (визгүй) нарын 13 дахь сарын цалинг ажил олгогчоос нэхэмжлэх асуудлаар Инчон хотын Хөдөлмөрийн хэлтэст өргөдөл гаргасан боловч өргөдөл гаргагч иргэдийн хүсэлтээр 2026.06.18-ны өдөр өргөдлийг хаасан.
- Иргэн Э.Т (F-6) нь 식당-д ажилласан хугацааны цалингийн үлдэгдэл 3,200,000 воныг нэхэмжилж өргөдөл гаргасан ба ажил олгогчтой холбогдон 2 хувааж барагдуулахаар тохирсон.
- Иргэн Б.Ж-гийн (визгүй) олгогдоогүй цалин 1,500,000 воныг нэхэмжилж Игсаны Хөдөлмөрийн хэлтэст 2026.06.11-ний өдөр өргөдлийг хүргүүлсэн.
- Иргэн Б.Б-гийн (хууль бус) үйлдвэрт машинистаар ажиллаад авч чадаагүй цалингийн үлдэгдэл 1,413,000 воныг олгуулахаар Хөдөлмөрийн хэлтэс (보령고용노동지청)-т өргөдөл гаргасан.
- Иргэн Д.Ч (визгүй), Ч.М (визгүй) нарын ажилласан хугацааны авч чадаагүй цалингийн талаарх өргөдлийг Сөүл хотын хууль зүйн туслалцаа үзүүлэх төвд гаргасан бөгөөд эцсийн шатны хурлын тов 2026.06.24-ний өдөр товлөгдсөн тухай мэдээллийг орчуулан өргөдөл гаргагчид хүргүүлсэн.
- Иргэн Н.А (визгүй), Э.Э (визгүй), Л.Б (визгүй) нарын 2024 оны 6 сард зочид буудалд ажилласан хугацааны олгогдоогүй цалинг нэхэмжилж Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлсэн.
- Иргэн Э.Т (визгүй), Б.Т (визгүй), Х.У (визгүй), С.У (визгүй), М.Д (визгүй), Б.А (визгүй) нарын сайн дураар нутаг буцах мэдэгдлийг Цагаачлалын албанд гаргаж, баталгааны хуудсыг өргөдөл гаргагчид илгээв.

1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ

- Эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж буй Эмч нарын нэгдсэн холбоо ТББ-тай хамтран хууль бусаар оршин сууж буй 7 Монгол иргэнийг эмнэлгийн үнэ

төлбөргүй үзлэг, шинжилгээнд 2026.05.30-ны өдөр хамруулж, жороор олгох эм олгон 830,000 воны эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэв.

- Иргэн Б.Х-г ЭММЗ-ийн Суурин хурлаар оруулж, хөгжлийн бэрхшээлтэй жагсаалтын заалтаар хөдөлмөрийн чадвар алдалтыг 80 хувиар 36 сараар тогтоолгон шийдвэрлүүлэв.
- Иргэн Д.Д-гийн халамжид хамрагдаж, групп тогтоолгох хүсэлтийг ХХҮЕГ-т албан тоотоор илгээж, хариу зөвлөмжийг өргөдөл гаргагчид хүргүүлсэн.
- Иргэн Л.Д (G-1) нь байнгын асаргаатай хүүхдийн халамж болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжид хамрагдах хүсэлт ирүүлснийг харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэгдэх шатандаа хянагдаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд зориулан "Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн онцлог, ажиллах арга" сэдвээр эцэг эхчүүдэд зориулсан цахим сургалтыг СБД-ийн Насан туршийн суралцахуйн төвийн багштай хамтран зохион байгуулж 8 иргэн оролцсон.



Зураг 2. Цахим сургалтын үеэр

1.1.4. Ур чадвартай ажилчны (Е-7-4) виз руу шилжихийг дэмжих үйлчилгээ

- Хөдөлмөрийн гэрээт ажилчны Е-9 визээс ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 виз руу шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 4 иргэнийг, Е-7-4 виз руу шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 7 иргэнийг шинээр бүртгэсэн.
- Е-7-4 визний асуудлаар нийт 52 иргэнтэй утсаар болон цахимаар холбогдож бүрдүүлэх баримт бичиг, оноо тоолох, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах, ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэг асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
- Иргэн Э.М-ийн (Е-9) Е-7-4 виз мэдүүлэх өргөдлийг хүлээн авч баримт бичгийг бүрдүүлэн ажил олгогч болон өргөдөл гаргагчтай холбоотой ажиллаж байна.
- Иргэн Н.Т (Е-7) нь виз сунгалтад хэлний оноо шаардлагатай байгаа тул Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалт (사회통합프로그램), түвшин тогтоох шалгалт (KIIP 사전평가)-д бүртгүүлсэн.

- Иргэн Т.С-ийн хүсэлтээр Цагаачлалын албаны “Hikorea” сайтын нууц үгийг 02-2650-4550 факсаар хүсэлт илгээн сэргээсэн. “Hometax” сайтаас 2024, 2025 оны татварын гэрчилгээ, “Socianet” сайтаас хэлний онооны гэрчилгээ (KIIP 사전평가) зэргийг гаргаж өгсөн. Виз мэдүүлэхээр баримт бичгийн бүрдлийг хангаж байсан боловч торгуулийн арга хэмжээ авхуулж байсан нь тогтоогдсон тул виз мэдүүлэх эрх үүсэхгүй нөхцөл үүсэж өргөдлийг хаасан.
- Иргэн Б.Б-гийн хүсэлтээр Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сайтад нэвтрэх нууц үг сэргээж, шалгалтад тэнцсэн гэрчилгээ (KIIP 사전평가)-г гаргаж цахимаар илгээв.
- Е-7-4 визний асуудлаар “Е-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 1170 байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн шалгалтад бүртгүүлэх аргачлал, ажлын зар, сургалтын зар, хүүхэд асрах чөлөөний талаарх Солонгосын хуулийн заалт, гадаад ажилчдын эрхийг хамгаалах шинэ баг томилогдсон тухай зэрэг 21 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн.

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

Тоон мэдээллийн агуулга		Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
		Иргэн	Олгуулсан дүн (вон)
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	1. Нутаг буцах зардал	3	1,540,010
	2. Цалин, илүү цагийн хөлс		
	3. Самсунгийн 13 дахь сарын цалин	4	13,964,123
	4. Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө		
	5. Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6. Гэнэтийн ослын даатгал		
	7. Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	2	
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	9. Олгогдоогүй хойшилсон цалин хөлс	2	5,390,000
	10. 13 дахь сарын цалин		
	11. Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	12. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	4	
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13. Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	3	3,579,224
	14. 13 дахь сарын цалин	3	7,000,000
	15. Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	16. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	13	830,000
Нийт олгуулсан мөнгөн дүн/иргэн		34	32,303,357

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
106	53	26	61	-	19

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

Үйлчилгээний төрөл	Тоо
1. Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	33
2. Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	21
3. Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлэх	25
4. Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	32

5. Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	0
6. Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	7
7. Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах	1
8. Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр солих болон гэнэт халагдсан тохиолдолд бүрдүүлэх материал, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлэх	8
9. Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	0
10. Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага, Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн хэлтэс, Төв бирж, Эрүүл мэндийн газар, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Үндэсний тэтгэврийн алба, Хөдөлмөр, халамжийн газар (Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга)	36
11. Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	5
12. Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	1
13. Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлэх	1
14. Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах	4
15. Визний ангилал солиулахад /Е9-өөс Е-7-4 виз рүү/ оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	56
16. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	31
17. Бусад мэдээлэл, зөвлөгөө	89
18. ХурДан төрийн цахим үйлчилгээ үзүүлэх	35
	Утсаар 226
	Цахимаар 108
	Танхимаар 56
Үзүүлсэн үйлчилгээний тоо	Нийт 393

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.06.01 - 2026.06.30)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ:

- 1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 11 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 24 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 0 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 9 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 33 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

- 2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 28 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 28 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 4 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 22 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 54 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд

Тайлант хугацаанд тус тасаг 293,061,815.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 65 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 94,759,008.00 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 06 дугаар сард нийт 56 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 36,231,038.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 29 даатгуулагчийн 18,972,500.00 төгрөг, сайн дурын даатгалын 27 даатгуулагчийн 17,258,538.00 төгрөг байна.

2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1) Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг танилцуулах, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар зөвлөгөө мэдээллийг өгөх үйлчилгээг утсаар (388),

цахимаар (28), танхимаар (70) нийт 488 иргэн, даатгуулагчид үзүүлсэн.

“Нийгмийн Даатгалын Тухай Нэг Хором” 2026 онд өндөр насны тэтгэврийн эрх хэрхэн үүсэх талаар лайваар мэдээлэл хүргэсэн.

- 2) 2026.06.25-ны өдөр БНСУ-ын хот дахь сургалтын төвд Е-9 визээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй 11 иргэнд Нийгмийн даатгалын тухай ойлголт, өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн нийгмийн баталгаагаа хангах, тэтгэврийн даатгалын шимтгэлийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар төлөхгүй, тус улсын хуулийн дагуу заавал хамрагдах тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх боломж, Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн албанд төлсөн шимтгэлийг нь буцаан олгох тухай, Сайн дурын даатгалын гэрээг хэрхэн байгуулах тухай сургалт зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
- 3) БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн амьдарч оршин суух нөхцөл, ажил эрхлэлт, нас хүйс болон нийгмийн даатгалд даатгуулсан байдал, нийгмийн даатгалын талаарх ойлголтыг тодорхойлох судалгааг 52 иргэнээс авсан.
- 4) Байгууллагын үйл ажиллагааг таниулах, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, түргэн шуурхай хүргүүлэх зорилгоор сар бүрийн сүүлийн 7 хоногийн 5 дахь өдөр болон Монгол тауны 2 давхарт 7 хоног бүрийн 2, 4 дэх өдөр холбогдох мэргэжилтнүүд хуваарийн дагуу ажилласан.

2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

Үйлчилгээ		Тоо	Өссөн дүнгээр
1. Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	11	201
	Сайн дурын даатгал	28	252
2. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Албан журмын даатгал)	Шинээр	9	185
	Дахин	0	18
	Хугацаа сунгасан	24	166
3. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Сайн дурын даатгал)	Шинээр	22	122
	Дахин	4	29
	Хугацаа сунгасан	28	173
4. Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал	97,703,250.00 38%	638,582,650.00 42%
	Сайн дурын даатгал	195,358,565.00 104%	1,057,803,166.61 94%
	Нийт	293,061,815.00 66.67%	1,696,385,816.00 63%
5. Гурав болон түүнээс дээш сарын	Албан журмын даатгал	18,972,500.00	183,408,428.00

	шимтгэлийн авлага барагдуулалт	Сайн дур	17,258,538.00	135,741,051.00
6.	БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт	Нэхэмжилсэн	17,527,820.00	58,606,090.00
		Олгосон	131,253,410.00	131,253,410.00
		Буцаан олголт авсан хүний тоо	28	28
7.	Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	388	2071
		Цахимаар	28	176
		Танхимаар	48	406

ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 36, youtube сувагт 8, байгууллагын seoulcenter.mlsp.gov.mn цахим хуудсанд 36 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 288,017 хандалт авсан.

Байгууллагын сошиал хуудсаар дамжуулан БНСУ-ын холбогдох хуулийг сурталчлах, иргэдэд мэдээлэх зорилгоор “Хуулийн булан”-г нээсэн ба “Цалингийн дэлгэрэнгүй хуудас”, “Үргүйдлийн эмчилгээний чөлөө”, “Ажлын цаг”, “Амралтын үеийн цалин хөлс”, “Хүүхэд асрах чөлөө” сэдвээр цуврал мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэв.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 11 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2026.06.19-ний өдөр цахимаар, ирсний дараах сургалтыг 2026.06.25-ны өдөр аж үйлдвэрийн салбарт ажиллахаар ирсэн 11 иргэнийг хамруулан Ёжү сургалтын төвд танхимаар тус тус зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл
- Ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.

Мугпу хотод 2026.06.20-ны өдөр БНСУ-ын Пусан хотод суугаа Консулын газар, Төрийн банк, Хаан банкны төлөөлөгчийн газруудтай хамтран явуулын үйлчилгээ үзүүлж, 4 иргэнд хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөвлөгөө мэдээллийг хүргэн, 30 иргэнд сурталчилгааны материалыг түгээн ажиллав.

Төвийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2026.06.26-ны өдөр Монгол Тауны гадна талбайд зохион байгуулж, 24 иргэнд хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалтай холбоотой зөвлөгөө мэдээлэл өгч, 64 иргэнд гарын авлага түгээсэн.



Зураг 2. Явуулын үйлчилгээний үеэр


Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинарт 4 удаа цахимаар, төвийн дотоод сургалтад 1 удаа танхимаар албан хаагчдаа хамруулсан.

3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ

Тайлант хугацаанд 31 иргэнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тулгамдсан асуудлаар нь ангилж үзвэл:

- сэтгэл гутралын асуудалтай 5;
- сэтгэл түгшилттэй 4;
- гэр бүлийн асуудалтай 6;
- нойрны өөрчлөлттэй 4;
- бусад шалтгаантай-12 иргэн байна.

“БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ирсний дараах сэтгэлзүй болон хөдөлмөрийн харилцаанд тулгамдсан асуудлаа хэрхэн шийдвэрлэх вэ” сэдэвт цахим сургалтыг 2026.06.12-ны өдөр 11 оролцогчийг хамруулан зохион байгуулав. Сургалтаар түгээмэл тулгардаг сэтгэлзүйн асуудлууд, тухайлбал ганцаардал, ажлын байрны стрессээс хэрхэн урьдчилан сэргийлэх, мөн хөдөлмөрийн харилцаанд үүсдэг хүндрэл, бэрхшээлүүдийг даван туулах арга замын талаар мэдээлэл өгсөн.



Зураг 3. Цахим сургалтын үеэр

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн эмч, сэтгэл засалч Д.Хонгорзултай хамтран “Хосын зөрчил юунаас үүсдэг вэ, түүнд хэрхэн менежмент хийх вэ” сэдэвт цахим сургалтыг 2026.06.21-ний өдөр зохион байгуулсан. Сургалтаар гэр бүлийн үнэ цэн, хосын харилцаанд үүсдэг зөрчил маргааны шалтгаан, түүнийг зөвөөр зохицуулах арга зам, зөрчилдөөнийг даван туулах болон үр дүнтэй харилцааг төлөвшүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, оролцогчдын сонирхсон асуултад хариулсан ба нийт 22 иргэн хамрагдав.

3.2. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил

- 2026.06.05-ны өдөр Узбекистан улсын Гадаад хөдөлмөр эрхлэлтийн газрын БНСУ дахь төлөөлөгчийн газартай танилцаж, туршлага солилцов.
- 2026.06.15-ны өдөр Филиппиний ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний газрын үйл ажиллагаатай танилцах хүсэлтийг тавьж Хөдөлмөрийн атташетай утсаар холбогдон 7-р сард уулзалт хийхээр тохирсон.
- Албан хаагчдыг чадавхжуулах, суугаа орны онцлогтой танилцах зорилгоор 2026.06.11-ний өдөр БНСУ-ын Парламентын ордноор зочлох ажлыг зохион байгуулж, төвийн нийт албан хаагчийг хамруулсан.

- Тасгийн дарга болон холбогдох мэргэжилтнүүд БНСУ-ын Дэ Бридж Интернэйшнл ТББ, Койкатай хамтран зохион байгуулсан “Нутаг буцаж буй Непал улсын хөдөлмөрийн гэрээт иргэдэд бизнесийн дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөр”-ийн 2 дахь шатны хаалтын арга хэмжээнд 2026.06.13-ны өдөр оролцож тус хөтөлбөрийг Монгол улсын хөдөлмөрийн ажилчдыг хамруулах хэрэгжүүлэх талаар туршлага судалсан.
- Албан хаагчид, нэгж, төвийн 2026 оны эхний хагас жилийн Гүйцэтгэлийн тайлан нэгтгэж, төвийн Гүйцэтгэлийн тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газарт 2026.06.10-ны өдөр хүргүүлэв.
- Шинээр ирсэн гэрээт ажилчдын судалгаа, ур чадвартай ажилчдын судалгаа, нутаг буцаж буй иргэдийн судалгааны мэдээллийн санг тус тус шинэчилсэн.
- Албан хаагчид Монгол таунд хуваарийн дагуу ээлжээр ажиллаж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн.
- Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай тогтмол эргэх холбоотой ажиллах зорилтын хүрээнд 51 иргэнтэй утсаар холбогдож, нөхцөл байдлыг нь тодруулж, хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- - - оОо - - -